

АЖДХолбооны Удирдах зөвлөлийн өргөтгөсөн хуралд гишүүн даатгалын компаниудын гүйцэтгэх захирлууд оролцсонтой холбогдуулж тавьсан илтгэл

Илтгэгч АЖДХ-ны гүйцэтгэх захирал Д.Цэвээнжав

Та бүхний энэ өдрийн мэндийг эрж, мэндчилж байна.

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал хэрэгжиж эхлээд 8 дахь жилдээ орлоо. Албан журмын даатгал хэрэгжүүлэх ажилд даатгагч, даатгуулагч, даатгалын зуучлагчид хохирол үнэлэгчид гээд олон зуун хүний оролцоотой даатгалын бүтээгдэхүүн байлаа.

2018 оны байдлаар Даатгалын нийт хураамжийн дүнд жолоочийн даатгалын хураамжийн орлого 26.3 хувийг эзлэх хэмжээнд хүрч жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамрагдалт 2012 оныхоос 2018 оны эцэс гэхэд даатгуулагч (655454/373480) -75.5 хувиар , хураамжийн хэмжээ (31005,9/15221,3)-100 гаруй хувиар өссөн байна.

Энэ даатгалыг хэрэгжүүлэх ажилд манай/АЖДХ/ холбоо хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргийн хүрээнд даатгагч, зуучлагч, хохирол үнэлэгчидтэй хамтран тулгамдсан олон асуудлыг шийдвэрлэсээр өнөөдрийн амжилт ололтыг бий болгож чадлаа. Бид энэ даатгалыг хэрэгжүүлэгчдийн хөдөлмөрийг хөнгөвчлөх, уялдаа холбоог хангах, мэдээлэл солилцох чиг үүргээ хэрэгжүүлэхдээ мэдээллийн орчин үеийн технологийг ашиглаж тодорхой үр дүн бий болгож чадсан юм.

Бидний ололт амжилт шулуун дардан замаар биш хардлага, хавчлага, атаа жөтөөний хар өдрүүдийг дамжихдаа хуулийн эцсийн зорилго нь улам тодорхой гэрэлтэж хөтөлсөөр байгаа явдалд сэтгэл хангалуун улам хүч нэмэн ажилласаар байна. АЖДХолбоо өнөөдөр хийсэн ажлаа хэнд ч танилцуулахад нүүр бардам гарт баригдах зүйл бүтээснээрээ бахархаж байна.

Бидний хийж гүйцэтгэх үндсэн чиг үүргийг төрийн хуулиар тодорхойлж өгсөн болохоор аливаа хэн нэгний хүсэл зорилгод хөтлөгдөх боломжгүй байгаа нь энэ цаг үедээ аз завшаан байсныг тэмдэглүүштэй.

АЖДХ-ны ажлын алба Даатгалын тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хуульд заасан үндсэн чиг үүргээ амжилттай хэрэгжүүлж байгааг холбооны удирдах зөвлөлийн 2019.01.30-ны өдрийн хуралдаанаар дүгнэж 01 тоот тогтоол гаргасан байгаа. Ер нь жил бүр үйл ажиллагааныхаа тайланг удирдах зөвлөлд танилцуулж цаашдын чиглэлээ тодорхойлж ажиллаж хэвшсэн гэдгийг хэлье. СЗХ-нд тайлан болон Удирдах зөвлөлийн шийдвэр хурлын тэмдэглэлийг хүргүүлдэг журам хэвшсэн болно.

Даатгалын тухай хуульд заасны дагуу Холбооны удирдах зөвлөлийг СЗХороо томилон ажиллуулахдаа даатгагчийн төлөөлөл Батжаргал, Батзул нар ажиллаж байгаа. Холбооноос хийж байгаа ажлыг та бүхэнд энэ хүмүүс хүргэж байгаа гэж ойлгож байна.

Холбооны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг дэлгэрэнгүйгээр та бүхэнд өгсөн байгаа. Мөн санхүүгийн тайланд аудит хийсэн дүгнэлтийг өдөр тутмын тогтмол гардаг 2 сонинд тавьж даатгуулагчдад хүргэсэн байгаа. Мөн монголны үндэсний радио, TV9 телевизээр зохих мэдээлэл сурталчилгаа хийгдсэн учраас дөрвөн өгүүлбэрт багтааж товч танилцуулга хийж та бүхний алтан цагийг хэмнэж санал бодлоо илэрхийлэхэд нь боломж гаргая.

Албан журмын даатгагчдын холбоо үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ цомхон орон тоо, бага зардлаар хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа цэгцтэй зохион байгуулалттай явуулахад онцгой анхаарч, жолоочийн даатгалын санг бүрэн бүрдүүлж санхүүгийн хувьд бүрэн чадавхитай боллоо.

Холбооны ажилтнуудыг зөв сонгож, тэдний хөдөлмөрлөх нөхцөлийг хангаж тэдний идэвхи санаачлагыг өрнүүлж ажилласаны нэг илэрхийлэл мэдээллийн нэгдсэн санг технологийн дэвшлийг ашиглан цогц систем болтол хөгжүүлж нэвтрүүлсэний үр шимийг та бид хүртэж байгааг хэлэхэд таатай байна.

Албан журмын даатгалыг ард иргэдэд ойлгуулах, улмаар зам тээврийн ослыг бууруулахад чиглэсэн сургалт сурталчилгааны ажлыг мэдээллийн бүх төрлийн хэрэгслийг ашиглан орон даяар жил бүр 100 орчим сая төгрөгийн зардал гаргаж ажилласнаар жолоочийн хариуцлагын даатгалд хамрагдалтыг тогтвортой өсгөж, даатгалын тохиолдлыг бууруулж чадсаныг тайлангийн тоо, мэдээ тод харуулж байгаа учир би давтан нурших шаардлагагүй.

Даатгуулагчдын хүсэн хүлээдэг мэдээлэл зөвлөгөө авах шуурхай үйлчилгээний талаар нэг дүгнэлт санааг хэлье.

Даатгал хийх үед даатгуулагчид зөвлөгөө өгөх ажлаас эхлээд Зам тээврийн ослын үеийн дуудлага, газар дээрх үзлэг хохирлын үнэлгээ хийх, нөхөн төлбөр авах зэрэг Албан журмын даатгалын амин чухал сэдэв болсон бүх талын үйлчилгээ үнэхээр зорилгоо хангаж чадахгүй байгаа, энэ ажил хэрхэн явагдаж байгаад дээд хяналт тавих / Жолоочийн даатгалын тухай хуулийн 26.1; Зөрчлийн тухай хуулийн 11 дүгээр бүлгийн 11.15 дугаар зүйл; Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.8-д заасан / үүрэгтэй байгууллага нь ажиллахгүй, анхан дунд шатанд нэгдсэн журамгүйгээс дур зоргын байдал ноёрхсоор байгааг засаж, зохих түвшинд нь оруулах шаардлагатай байна. Энэ талаар 2017 оны тайлан хэлэлцүүлэхэд онцгойлон авч үзсэн боловч ямарч / уг нь шуурхай албаны нийтлэг журам баталж орон нутагт зарим арга хэмжээ авах санал яригдсан/ ажил хийгдээгүй төдийгүй ажил сайжруулах тухай санаачлагыг өөрсдийг нь шүүмжилж байна гэж ойлгоод шүгэл үлээгчийг дарж авах зохион байгуулалтад хэсэг бүлгийг оруулсан нь үнэхээр харамсалтай. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалыг хэрэгжүүлэх ажил хаана аль даатгагч дээр доголдож байгааг даатгуулагчид, аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс, Тээврийн цагдаагийн тасгийн ажилтнууд шүүмжилж байна. Үүнийг хүлээн авч ажил болгох сонирхол байхгүй юм даа.

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд дээрх дүгнэлтээс гадна тулгамдаж байгаа зарим асуудлыг нэмж товчхон илтгэе.

Өнгөрсөн он жилүүдэд жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаанд мөрдөх журам зааврууд цаг үеийн шаардлагыг бүрэн биш ч гэсэн тусгаж 2-3 удаа өөрчлөгдсөн боловч Даатгалын тухай, Жолоочийн даатгалын тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах ажил үр дүнд хүрээгүй, ажил нь явахгүй байна.

Мөн нийт хураамжийн орлогын 50 гаруй хувийг зарцуулдаг нөхөн төлбөр олгох ажлын суурь үндэс хохирлын үнэлгээ хийх нэгдсэн аргачлалгүй нэгдсэн журамгүй өдий хүрлээ. Энэ хуулийн амин сүнс шуурхай алба ч нэгдсэн журамгүй байгаа нь хэнд ашигтай байна вэ? Зөвхөн даатгуулагчид л хохирсоор байна.

Жолоочийн хариуцлагын даатгалыг хэрэгжүүлэх ажил аймаг сумын түвшинд маш хангалтгүй хамрагдалт 70 хувьтай зохион байгуулагдаж байгаа нь уг хуулийн нийгэмд болон ирээдүйд хэрэгжүүлэх албан даатгалын хэрэгжилтэд сөрөг нөлөө үзүүлж байгааг анхаарахыг хүсэхгүй байгааг юу ч гэлтэй билээ.

Жолоочийн хариуцлагын даатгал эрхлэх зөвшөөрөл олголт (энэ даатгалыг амархан мөнгө олох арга гэж сэтгээд даатгуулагчид, нийгэмд үйлчлэх үйлчилгээг сайжруулах талыг орхигдуулахад хүртэл) хэт хавтгайрч, даатгалын үйл ажиллагааны бэлтгэлгүй хүмүүс ажиллаж тэд үйлчилгээг орхигдуулж мэдлэг, сэтгэл дутмаг хандлага нь мэдээллийн чанарт муугаар нөлөөлж байна. Холбооны мэдээллийн санд ирүүлсэн мэдээлэлд шалгалт хийж үзэхэд 48 хувь нь шаардлага хангахгүй байна. 2017 оны даатгалын гэрээ, нөхөн төлбөрийн

мэдээлэлд хэсэгчлэн шалгалт хийсэн дүнгээр мэдээллийн чанар хангалтгүй байгаа тухай даатгагч нарт албан бичгээр хүргүүлсэн. Түүний мөрөөр ямарч ажил хийгээгүй үр дүн гараагүй болохыг 2018 оны тайлангийн мэдээлэлийг түүвэрчлэн шалгасан байдлаас та бүхэн харж болно. Хүснэгт харуулья. №1, 1а №2, 2а

Ер нь жилийн эцсийн тайлан ирүүлж тулгалт хийсэн дүнгээс ч харахад ажил яаж явагдаж байгаа нь ойлгомжтой харагдаж байгаа. Хүснэгт харуулья. №3, 3а

Эцсийн дүнд Жолоочийн даатгалын тухай хууль, Даатгалын тухай хуулийн 12¹ зүйлд ч мөн Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудад үүрэг хүлээсэн Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагааны явцад тавих хяналт зохион байгуулагдахгүй өдий хүрсэн явдалд шүүмжлэлтэй хандах цаг болсон байна.

Би илтгэлийнхээ 2 дахь хэсэг буюу жолоочийн албан журмын даатгалын хураамжийн орлого, түүний зарцуулалттай холбоотой хэсгийг товч танилцуулья.

Жолоочийн даатгалын тухай хууль 2011 онд батлагдсан 2012 оноос хойшхи үйл ажиллагааны статистик та бүхэнд байгаа болохоор зөвхөн хураамжийн орлого, түүний зарцуулалтын талаар танилцуулья.

Даатгагчдаас Жолоочийн даатгалын санд төвлөрүүлсэн хөрөнгийн тухайд Хүснэгт №4

Жолоочийн даатгалын санг бүрдүүлэх эх үүсвэрүүдийн нэг нь Жолоочийн даатгалын тухай хуулийн дагуу Жил бүр Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан тушаалын дагуу даатгагч нараас төвлөрүүлж байгаа хөрөнгө бөгөөд уг хөрөнгийг хуульд заасан зориулалтаар даатгагчийн үйл ажиллагаанд зориулж удирдах зөвлөлөөс баталсан хэмжээнд зарцуулагдаж байна.

Холбооны зүгээс Жолоочийн хариуцлагын даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалт сурталчилгаа, хяналт шалгалт явуулсаны үр дүнд хураамжийн хэмжээ өсч байсан ч даатгагч нараас төвлөрүүлэх хөрөнгийн хувийг бууруулах чиглэл барин ажилласаар ирсэн нь харагдана. Хүснэгт №4

Жолоочийн даатгалд даатгуулагчдийн төлсөн хураамжийн орлого яаж хуваарьлагдаж байгааг хүснэгт №4а-аас харж болно.

Даатгуулагчдын хураамжийн орлогоос Диаграм №5-аас харахад 53 орчим хувийг зам тээврийн осол буюу даатгалын тохиолдлын хохирогчдод олгосон хөрөнгө эзэлж, зуучлагчид даатгалын гэрээний 1/3 орчимыг хийж түүнийхээ нийт хөлсөнд хураамжийн орлогын 4,3 хувийг авч байна.

Жолоочийн даатгалын тухай хуульд заасны дагуу АЖДХ-нд 1,8 орчим хувийг төвлөрүүлж үлдсэн 40 орчим хувийг даатгагч нар зарцуулж байна.

Бид ашиг гэж хэлээгүй шүү. Мөн Даатгалын тухай хуулийн 14.2 ; 14.3- д заасаны дагуу Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөөц санг та бүхэн байгуулж байршуулсан байх ёстой. Тэр нөөц сангийн хөдөлгөөнд СЗХ-ноос хяналт тавьж байдаг бүз.

Албан журмыг даатгалын хуулинд буюу жолоочийн даатгалын санд ямар эх үүсвэрээс хөрөнгө төвлөрүүлэхийг Жолоочийн даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйлд тодорхой зааж өгсөн бөгөөд сангийн үйл ажиллагааг СЗХ-ны баталсан журмаар зохицуулж байна.

Жолоочийн даатгалын сангийн хөрөнгийн 11,8 хувийг даатгуулагчдын төлсөн хураамжийн орлогоос, бусад нь аймаг нийслэлийн төсвөөс/ АТБӨЯХАТ-ын 10 хувь/ болон холбооны мэдээллийн санг төлбөртэй ашиглуулсаны орлого, бусад үйл ажиллагаанаас орсон орлогоос бүрдэж байна. Хүснэгт №6 , ба харуулья

Албан журмын даатгалын сан буюу Жолоочийн даатгалын сангаас хууль журамд заасан хэмжээнд зарцуулаад үлдсэн нь албан журмын даатгалын сан хэлбэрээр тусгай

дансанд байршиж байна. Даатгагчдаас төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт үлдэгдлийг хүснэгт №7- оор харуулья.

Хуульд заасан эх үүсвэрээр нийт хуримтлуулсан хөрөнгө гэвэл 2019 оны эцсийн байдлаар /даатгагчдаас төвлөрсөн хөрөнгийн үлдэгдэл 267,9 сая, төсвөөс төвлөрсөн хөрөнгө 11,6 тэрбум/ нийт 11,9 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Даатгуулагчдын төлсөн хураамжийг хаана яаж хуваарьлагдаж байгааг та бүхэн ойлгосон байх. Тэгвэл жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын бүх үйл ажиллагаанд хэн ямар үүрэгтэй оролцдог тухай ажлын зураглалыг та бүхэнд танилцуулья.

Албан журмын даатгалын гэрээг даатгалын зуучлагчаар, төлөөлөгчөөр буюу даатгагчид хийж байгаа. Мөн энэ үйл ажиллагаанд Даатгалын тухай хуулийн 12¹.3.1-д заасан үүргийг хангахын тулд АЖДХолбоо түүний мэдээлийн сан оролцож байна. Оролцох оролцохдоо энэ даатгалын үйл ажиллагааны 1/3- ийг гүйцэтгэж байна. Мөн мэдээллийн санг хөтлөх технологийг бэлтгэх, сургалт сурталчилгааны ажилд бага биш хөрөнгө зарцуулж байгааг . Хүснэгт №7-оос харж болно.

Цаашдаа шуурхай албаны дуудлага төвлөрүүлэх, хохирлын үнэлгээтэй холбоотой материал бүрдүүлэхтэй холбогдуулж мөн тээврийн цагдаагийн байгууллагад зам тээврийн ослын мэдээлэл шилжүүлэхтэй холбогдуулж АЖДХ-ны үүрэг улам нэмэгдэх шаардлагатай байна. Энэ ажлыг нэгтгэж зохион байгуулах нь хэн нэгний эрх ашиг гэхээс илүү улсын хэмжээнд хариуцлагыг өндөржүүлэх, хяналтыг сайжруулах төрийн бодлоготой нийцэж ажиллана гэсэн үг юм. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний болон түүний эзэмшигчийн хариуцлага нь ил тод нээлттэй болоход ач холбогдолтой байх болно.

Эрхэм нөхөд өө.

АЖДХ-ны зорилт зорилго маш тодорхой. Товчхон хэлэхэд холбогдох хуулиар хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэхийн тулд менежмент сайтай байх, дэвшилтэт технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхийг үргэлж эрмэлздэг, гүйцэтгэдэг байх явдал юм.

Бид энэ зорилгодоо хүрэхийн тулд 2022 он хүртэл баримтлах хөгжлийн стратегийг боловсруулж Удирдах зөвлөлөөр батлуулсан байгаа. Мөн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг жил бүр Удирдах зөвлөлд танилцуулж шийдвэр гаргуулж байгаа. Тэр шийдвэрт чиглэл болгосон ажлыг тууштай хэрэгжүүлж ажиллах нь бидний баримтлах хатуу зарчим байх болно.

Холбоо нь цаашид үйл ажиллагаагаа явуулахдаа дараах чиг хандлагыг баримтлан ажиллана.

Албан журмын даатгал юуны өмнө жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хууль эрхзүйн орчныг яаралтай шинэчилж төгөлдөржүүлэх, албан журмын даатгалд оролцогчдын эрх ашгийг адил түвшинд авч үзэх, тэдний оролцоог хангах зарчмыг тууштай барьж ажиллана.

- ✓ Жолоочийн даатгалын санг нөөц бололцоогоо ашиглан бүрдүүлж, улмаар Жолоочийн даатгалын тухай хуулийн 22.1.1, 22.1.4-д заасан санхүүжилтийг зогсоож зах зээлийн зарчмаар харилцан үүрэг хүлээж хийсэн ажилдаа санхүүжилт авах болно. Хуулийн төсөлд энэ санаагаа суулгаж өгсөн байгаа.
- ✓ Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх эрхийг даатгагч, зуучлагч нарт хэт хавтгайруулж олгосоныг цэгцэлж, цаашлаад хариуцлагын даатгалын гэрээ байгуулахаас нөхөн төлбөрийг хохирогчид олгох хүртэлх үйл ажиллагаа хэт олон байгууллагаар дамжихгүйгээр нэг цонхоор явж дуусдаг болох нь даатгуулагчдаас төлөх хураамжийн хэмжээг бууруулах нөхцөл байх болно гэж үзэж байна.

- ✓ Даатгалын тохиолдол байнга гаргаж хураамжийн орлогын 50 гаруй хувийг хохирогчийн нөхөн төлбөрт олгуулсаар байгаа нийт даатгуулагч нарын 5 хүрэхгүй хувьд хүлээлгэх хариуцлагын механизмийг өөрчлөх замаар нөхөн төлбөрийн хэмжээг бууруулж болно гэж үзэж байна.
- ✓ Даатгалын тохиолдол огт гаргаагүй хариуцлага өндөртэй даатгуулагчдыг урамшуулах эрх зүйн орчинг бүрдүүлэхэд анхаарч хариуцлагын даатгалыг үзлэг оношилгоо, засвар үйлчилгээний байгууллагатай холбож хамтран ажиллах чиглэл баримтална.
- ✓ Албан журмын даатгалын үйл ажиллагааг цахимжуулахад мэдээллийн технологийг тууштай ашиглаж уг даатгалын бүтээгдэхүүний өртөг зардлыг бууруулах талаар тууштай ажиллах болно. Энэ ажлыг амжилттай зохион байгуулсанаар даатгуулагчидаас төлөх хураамжийн хэмжээг бууруулах боломж бүрдэнэ.

2019 онд Жолоочийн даатгалын санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг 2018 оны хураамжийн орлогод тооцсон дүнгээс 1,6 хувиар тооцож төвлөрүүлэх тухай Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хорооны даргын шийдвэрт санал нэгдэж ажиллахыг та бүхэнд уриалж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа

**МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ГЭРЭЭНИЙ
МЭДЭЭЛЭЛД ШАЛГАЛТ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН /2018.03.21/**

Хүснэгт №1

Мэдээллийн санд байгаа 2017 оны 01-р сарын 01-ээс 12-р сарын 31 –ны хооронд хийгдсэн жолоочийн даатгалын гэрээний мэдээлэлд шалгалт хийсэн тайлан.

Даатгалын 15 компаний 10,405 ширхэг гэрээний мэдээллийг бүрэн шалгаж дууссан. Нийт шалгасан гэрээний 4,894 буюу 47% нь мэдээлэл бүрэн орсон, 4,829 буюу 46,4% нь мэдээлэл дутуу орсон гэрээ эзлэж байна. Мэдээлэл дутуу орсон гэрээний дийлэнх хувийг даатгуулагчийн жолооны үнэмлэхний дугаар, дэлгэрэнгүй хаяг, улсын дугаар, нэр дурьдсан жолоочийн жолооны үнэмлэхний дугаар зэрэг мэдээлэл эзэлж байна.

д/д	ДК-ны нэрс	2017онд байгуулсан гэрээний тоо	Шалгасан гэрээний тоо	Шалгасан гэрээний хувь	Бүрэн гэрээний тоо	Бүрэн гэрээний хувь	Бүрэн бус гэрээний тоо	Бүрэн бус гэрээний хувь
1	Соёмбо даатгал	20,422	570	2.8%	310	54.3%	260	45.6%
2	Бодь даатгал	71,466	1627	2.2%	549	58.9%	396	41.9%
3	Ган зам даатгал	395	395	100%	386	97.7%	9	2.2%
4	Мөнх даатгал	6,747	340	5.03%	67	19.7%	273	80.3%
5	УБхотын даатгал	116	116	100%	42	36.2%	74	63.8%
6	Гэр даатгал	13,090	269	2.05%	134	49.8%	135	50.2%
7	Практикал даатгал	40,448	967	2%	333	34.5%	634	65.5%
8	Миг даатгал	98,468	1,994	2.02%	1009	50.6%	985	49.4%
9	Монре даатгал	27,753	720	2.5%	340	47.20%	380	52.7%
10	Номин даатгал	43,071	861	2%	485	56.30%	376	43.7%
11	Тэнгэр даатгал	38,976	780	2%	451	57.80%	329	42.2%
12	Мандал даатгал	21,212	600	2.8	348	42%	252	58%
13	Ард даатгал	37,528	751	2.00%	197	26%	554	74%
14	Монгол даатгал	114,798	113	0.90%	61	53%	52	49%
15	Хаан даатгал	13,714	302	2.2%	182	60%	120	39.7%
	НИЙТ	548,204	10,405	1.8%	4,894	47%	4,829	46.4%

Мэдээлэл дутуу орсон задаргааг хүснэгтээр харуулав. /Давхардсан тооноор орсон болно/

Хүснэгт №1а

д/д	Мэдээлэл	Соёмбо даатгал	Бодь даатгал	Монре даатгал	Ган зам	Мөнхдаатгал	УБ хогын даатгал	Гэр даатгал	Практикал даатгал	Ард даатгал	Монгол даатгал	Миг даатгал	Номин даатгал	Тэнгэр даатгал	Мандал даатгал	Хаан даатгал
1	Даатгуулагчийн овог, нэр	1	-	-	-	1	-	-	1	2	-	-	-	-	-	-
2	Даатгуулагчийн туршлага	-	-	-	-	122	13	-	14	23	1	1	-	-	-	-
3	Даатгуулагчийн жолооны үнэмлэхний дугаар	122	286	166	-	256	-	42	156	153	12	188	85	82	80	54
4	Даатгуулагчийн хаяг	59	143	85	-	2	-	36	440	415	25	280	135	128	121	12
5	Даатгуулагчийн утасны дугаар	4	15	3	-	-	-	-	36	12		44	2	4	5	-
6	Тээврийн хэрэгслийн улсын дугаар	11	26	100	-	-	-	4	29	19	2	30	-	-	-	3
7	Тээврийн хэрэгслийн аралын дугаар	-	4		-	149	-	-	4	-		13	-	-	-	-
8	Нэр дурдсан жолоочийн регистрийн дугаар	-	-	3	-	-	-	-	-	-	2	2	-	-	1	-
9	Нэр дурдсан жолоочийн овог, нэр	-	1	-	-	1	3	-	2	16		2	-	-	1	-
10	Нэр дурдсан жолоочийн үнэмлэхний дугаар	132	155	178	-	6	63	80	230	158	26	502	152	114	101	79
11	Нэр дурдсан жолоочийн утасны дугаар	7	4	3	9	-	49	4	15	23	1	80	32	18	12	1
	НИЙТ	336	634	538	9	537	128	166	927	821	69	1.142	406	346	321	148

МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ГЭРЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛД ШАЛГАЛТ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Мэдээллийн сангийн 2018 оны 01-р сарын 01-ээс 12-р сарын 31-ны хооронд хийгдсэн жолоочийн даатгалын гэрээний мэдээлэлд шалгалт хийлээ.

Даатгалын компаниудын 2018 онд байгуулсан жолоочийн даатгалын нийт гэрээний мэдээллийг шалгахад нийт шалгасан 4002 гэрээний 52% буюу 2083 гэрээний мэдээлэл бүрэн орсон, 48% буюу 1919 гэрээний мэдээлэл дутуу орсон байна.

Мэдээлэл дутуу орсон гэрээний дийлэнх хувийг даатгуулагчийн жолооны үнэмлэхний дугаар, нэр дурьдсан жолоочийн жолооны үнэмлэхний дугаар зэрэг мэдээлэл эзэлж байна.

Хүснэгт №2

Даатгалын компани	2018 онд байгуулсан гэрээний тоо	Шалгасан гэрээний тоо	Шалгасан гэрээ /%/	Бүрэн гэрээний тоо	Бүрэн гэрээ /%/	Бүрэн бус гэрээний тоо	Бүрэн бус гэрээ /%/
Соёмбо даатгал	25,794	511	2%	233	46%	278	54%
Миг даатгал	106,507	163	0,23%	65	39,9%	98	60,1%
Мөнх даатгал	8,444	432	5.1%	52	12%	380	88%
Монгол даатгал	126,415	645	0.5%	303	47%	342	53%
Практикал даатгал	51,289	100	0,3%	60	60%	40	40%
Гэр даатгал	3,106	220	7,1%	163	74%	57	26%
Уб хотын даатгал	113	112	100%	98	88%	14	13%
Номин даатгал	43,088	100	0.2%	41	41%	59	59%
Тэнгэр даатгал	37,804	100	0.3%	68	68%	32	32%
Бодь даатгал	92,599	100	0.1%	40	40%	60	60%
Ган зам даатгал	494	494	100%	486	98%	8	2%
Монре даатгал	48,628	420	1,4%	165	40%	255	60%
Ард даатгал	52,019	100	0.2%	34	34%	66	66%
Мандал даатгал	7,113	355	5%	219	62%	136	38%
Хаан даатгал	52,115	150	0,9%	56	37,4%	94	62,6%
Нийт	655,528	4,002		2,083	52%	1,919	48%

Хүснэгт №2а

Мэдээлэл дутуу орсон гэрээний задаргааг хүснэгтээр харуулав.

/Давхардсан тоогоор орсон/

Даатгалын компани	Даатгуулагчийн овог, нэр	Даатгуулагчийн туршлага	Даатгуулагчийн жолооны үнэмлэхний	Даатгуулагчийн хаяг	Даатгуулагчийн утасны дугаар	Тээврийн хэрэгслийн улсын дугаар	Тээврийн хэрэгслийн аралын дугаар	Нэр дурдсан жолоочийн регистерийн дугаар	Нэр дурдсан жолоочийн овог, нэр	Нэр дурдсан жолоочийн үнэмлэхний дугаар	Нэр дурдсан жолоочийн утасны дугаар	Дутуу оруулсан мэдээллийн тоо
Соёмбо даатгал	0	2	104	70	3	1	1	1	3	130	10	325
Миг даатгал	0	0	17	35	0	6	0	0	0	59	0	117
Мөнх даатгал	0	0	278	1	0	0	204	1	0	7	0	491
Монгол даатгал	4	4	156	78	5	0	0	0	8	147	7	409
Практикал даатгал	0	0	7	21	0	5	0	0	0	21	1	55
Гэр даатгал	0	0	22	4	0	0	0	0	0	36	1	63
Уб хотын даатгал	0	4	0	0	0	0	0	0	2	11	8	25
Номин даатгал	0	3	16	6	1	0	0	0	0	23	0	49
Тэнгэр даатгал	1	0	9	0	0	0	0	0	1	24	0	35
Бодь даатгал	0	1	20	5	1	0	0	0	0	21	0	48
Ган зам даатгал	0	0	0	0	0	0	0	0	0	1	7	8
Монре даатгал	0	0	39	94	4	44	1	0	4	145	4	335
Ард даатгал	0	1	18	3	2	1	0	0	0	21	1	47
Мандал даатгал	0	13	63	36	0	3	0	0	1	62	4	182
Хаан даатгал	0	0	18	54	1	3	0	0	0	42	0	118
Нийт	5	28	767	407	17	63	206	2	19	750	43	2307

2018 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН ТУЛГАЛТ ХИЙСЭН ТУХАЙ

Мэдээллийн сангийн 2018 оны жилийн эцсийн тайлан тулгалтыг даатгалын 15 компанитай жолоочийн даатгалын гэрээний тоо, хураамжийн дүн, олгосон нөхөн төлбөрийн тоо, дүнгээр тайлан тулгалт хийсэн.

Тайлан тулгалтын дэлгэрэнгүй мэдээллийг доорх хүснэгтээс харна уу.

Хүснэгт

№3

Жолоочийн даатгалын гэрээний тоо, хураамжийн тоо:

Хүснэгт №01./МИИС системээс 2018 оны 1-р сарын 01-ээс 12-р сарын 31-ний өдөр хүчинтэй гэрээний тайланг гаргасан

болно./

д/д	Компанийн нэр	Гэрээ						Даатгуулагч цуцалсан Г.тоо	Хураамжийн дүн	Даатгагч цуцалсан Г.тоо	Хураамжийн дүн
		Санхүүгийн тайлан		МИИС систем		Зөрүү					
		Г.тоо	Хураамж	Хүчинтэй Г.тоо	Хураамж	Г.тоо	Хураамж				
1	Соёмбо	26,414	1,363,552,365	25,794	1,350,630,637	(620)	(12,921,728)	1,561	72,715,973	-	-
2	Миг	120,007	5,155,639,734.82	106,507	4,864,999,042	(13,500)	(290,640,693)	4,016	206,482,383	6,823	318,373,155
3	Мөнх	8,579	622,998,828	8,444	622,643,285	(135)	(355,543)	342	11,494,682	238	19,171,892
4	Монгол	123,838	6,339,613,091	126,415	6,199,369,417	2,577	(140,243,674)	5,282	243,229,323	5,376	354,093,758
5	Практикал	50,341	2,473,120,881.48	51,289	2,405,545,855	948	(67,575,026)	3,914	111,609,123	-	-
6	Гэр	3,592	177,032,696	3,106	158,350,164	(486)	(18,682,532)	444	20,615,819	-	-
7	УБ хот	113	8,509,094	113	8,509,094	-	-	-	-	-	-
8	Номин	42,555	2,001,858,511	43,088	2,034,684,131	533	32,825,620	2,694	126,612,704	3,174	194,431,869
9	Тэнгэр	39,844	2,240,725,431.00	37,804	2,168,741,400	(2,040)	(71,984,031)	2,495	104,590,370	1,716	121,803,363
10	Бодь	92,599	4,020,778,603	92,599	4,020,778,603	-	-	6,124	274,192,955	2,998	150,134,602
11	Ган зам	499	33,893,095	494	33,747,268	(5)	(145,827)	5	173,052	-	-
12	Монре	48,169	2,326,245,633.00	48,628	2,353,473,002	459	27,227,369	5,274	262,893,162	1,966	101,113,657
13	Ард	52,838	2,445,140,742.68	52,019	2,388,805,136	(819)	(56,335,607)	3,727	173,633,078	2,041	109,505,087
14	Мандал	7,641	538,045,217	7,113	503,528,149	(528)	(34,517,068)	849	66,821,726	911	66,616,772
15	Хаан	55,797	2,618,317,612	52,115	2,455,778,436	(3,682)	(162,539,176)	4,973	219,188,421	2,443	118,663,854
	Нийт	672,826	32,365,471,535	655,545	31,569,681,364						

Нөхөн төлбөрийн тайлан мэдээ:

/ МИИС системээс нөхөн төлбөрийн мэдээг 2018 оны 2 дугаар сарын 20-ны өдрөөс тасалбар болгосон./

Хүснэгт №3а

д/д	Компанийн нэр	Нөхөн төлбөр					
		Санхүүгийн тайлан		МИИС систем		Зөрүү	
		Т.тоо	Олгосон НТ	Т.тоо	Олгосон НТ	Т.тоо	Олгосон НТ
1	Соёмбо	1121	685,803,332	984	631,075,482	(137)	(54,727,850)
2	Миг	5,104	2,913,392,876	3,919	2,896,245,432	(1,185)	(17,147,444)
3	Мөнх	66	51,489,047	65	51,489,047	-	-
4	Монгол	5,498	3,075,146,090	5,428	3,075,146,096	(70)	-
5	Практикал	1,818	1,112,161,204	1,793	1,112,161,204	(25)	-
6	Гэр	455	249,965,460	446	249,648,560	(9)	(316,900)
7	УБ хотын	5	1,742,000	5	1,742,000	-	-
8	Номин	1,942	1,104,270,802	1,864	1,104,270,829	(78)	-
9	Тэнгэр	1,724	1,039,487,219	1,725	1,039,687,219	1	200,000
10	Бодь	4,080	2,106,758,711	4,080	2,106,758,711	-	-
11	Ган зам	19	11,633,400	18	11,633,400	(1)	-
12	Монре	2,622	1,561,017,305	2,554	1,560,897,486	(68)	(119,819)
13	Ард	1,780	1,072,935,053	1,606	1,072,935,053	(174)	-
14	Мандал	928	504,514,256	930	503,690,503	2	(823,753)
15	Хаан	2,559	1,450,867,188	2,509	1,441,281,914	(50)	(9,585,274)
Нийт		29,721	16,941,183,943	27,932	16,865,988,436		

Даатгагчидаас Жолоочийн даатгалын санд төвлөрүүлэх хөрөнгийн тухайд

Хүснэгт-4/Мян. төг/

	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Нийт хур. орлого		16 298 075 ,6	15 507 400,2	19 345 095,5	22 418 521,9	26 618 949,8	29 008 226,0	31 569 681,3
Төвлөрүүлэх хувь, хэмжээ		Даатгагч тус бүрээс 30 сая.төг	Нийт Хур.Ор-н 3 хувь	ОТХ-н 3 хувь	ОТХ-н 2,5 хувь	ОТХ-н 2 хувь	ОТХ-н 1,8 хувь	ОТХ-н 1,8 хувь
Төвлөрүүлсэн хөрөнгө	110000.0	328 000,0	473 739,0	459 448,4	447 311,0	390 133,0	444 625,2	475 734,4

- ▶ Холбоо нь нийт хураамжийн хэмжээг өсгөх замаар даатгагчидаас авах хөрөнгийн хэмжээгээ нэмэгдүүлэх зорилго тавиагүй зөвхөн Даатгалын компаниудын эрх ашигт зориулагдсан үйл ажиллагааны зардалтай уяж төвлөрүүлэх хөрөнгийн хувийг тогтоолгох зарчим барьж ажилласаныг дээрх судалгаа нотолж байна.


Жолоочийн даатгалд даатгуулагчидын төлсөн хураамжийн орлогын хуваарилалт

Хүснэгт-4а /мян.төг/

Утга	2012	2013	2014	2015	2016	2017	2018	Нийт
Нийт хур. Орлого	16 298 075,60	15 507 400,20	19 345 095,50	22 418 521,90	26 618 949,80	29 008 226,00	31 569 681,30	160 765 950,30
Нийт нөхөн төлбөрт олгосон	4 790 865,90	8 953 021,10	11 285 696,30	14 365 915,70	14 217 524,70	15 201 454,00	16 865 988,40	85 680 466,10
Хур.орлогод эзлэх хувь	29,39%	57,80%	58,30%	64,00%	53,40%	52,40%	53,42%	53,30%
Хур. Орлогод зуучлагчийн эзлэх хувь		10%	11,80%	30,50%	34,70%	34,200%	35,30%	
Зуучын хур. Орлогын дүн		1 550 740,02	2 292 605,60	6 859 400,10	9 251 430,60	9 936 279,30	11 165 746 ,4	29 890 455,62
зуучлалын хөлс/17%/		155 074,00	389 691,90	1 166 098,02	1 572 743,20	1 689 167,48	1 898 176,80	6 870 951,40
Хур.орлогод эзлэх хувь		0,90%	2,00%	5,20%	5,90%	5,80%	6,01%	4,27%
ЖДСанд төвлөрүүлсэн дүн	328 000,00	473 739,00	459 448,40	447 311,00	390 133,00	444 625,20	475 734,40	3 018 991,00
Хур.орлогод эзлэх хувь	2,01%	3,05%	2,40%	2,00%	1,50%	1,53%	1,51%	1,88%
Даатгагч нарт Үлдэх орлого	11 179 209,70	5 925 566,10	7 210 258,90	6 439 197,18	10 438 548,90	11 672 979,32	12 329 781,70	65 195 541,80
Хур.орлогод эзлэх хувь	68,60%	38,25%	37,30%	28,80%	39,20%	40,27%	39,06%	40,55%

Даатгуулагчид 2012-2018 онд нийт 160 765 950,3 мянган төгрөгийн хураамж төлсөн бөгөөд уг орлогын зарцуулалт дараах байдалтай байна.

Диаграм №5
/Мян. төг




2011-2018 оны даатгалын сангийн орлого бүрдүүлэлт

мян.төг

д/д	Орлогын төрөл	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	НИЙТ	Нийт орлогод эзлэх хувь
1	Авто тээврийн болон өрөө явагч хэрэгслийн албан татварын 10 хувь /АТБӨЯХАТ/			2,290,996.6	2,682,136.2	1,696,185.0	2,033,381.1	5,485,072.9	3,574,176.7	17,761,948.5	67.2%
2	Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа даатгагчдаас төвлөрүүлэх хөрөнгө	110,000.0	328,000.0	473,739.0	459,448.4	447,311.0	390,133.0	444,625.2	475,734.4	3,128,991.1	11.8%
3	Жолоочийн даатгалын хууль тогтоомжийн зөрчилд ногдуулсан торгуулийн орлого				2,208.0	3,936.0	480.0			6,624.0	0.03%
4	Мэдээллийн санг төлбөртэй ашиглуулсны орлого			3,000.0	27,500.0	32,697.1	34,989.2	50,699.9	150,153.5	299,039.7	1.1%
5	Нөхөн төлбөрийн буцаан төлөлтийн орлого			9,725.6	60,719.9	94,902.4	100,919.3	102,539.2	39,711.5	408,517.9	1.5%
6	Хүүгийн орлого		7,814.2	23,767.0	223,462.3	631,008.3	518,692.4	833,540.6	2,595,066.7	4,833,351.5	18%
	ДҮН	110,000.0	335,814.2	2,801,228.3	3,455,474.8	2,906,039.8	3,078,595.0	6,916,477.7	6,834,842.8	26,438,472.7	100%

2012-2018 оны даатгалын сангийн орлого бүрдүүлэлт



Тайлбар: Аймаг Нийслэлийн ЗДТГ-аас 2016 онд АТБӨЯХАТ-ыг бүрэн төвлөрүүлээгүйгээс үүссэн авлага 2 083 204,9 мянган төгрөгийг 2017 онд барагдуулсныг хасч тооцов.

- ЖДсангийн Хүснэгт №7 -аар харуулья.

Даатгагчдаас төвлөрүүлсэн хөрөнгийн тайлан										
мян.төг										
Үзүүлэлт	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	ДҮН	
Даатгагчдаас төвлөрсөн орлогын дүн	110 000,0	328 000,0	473 739,0	459 448,4	447 311,0	390 133,0	444 625,2	475 734,4	3 128 991,1	
Даатгагчдаас төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжсэн шууд зардал	Мэдээллийн сангийн ажиллагсдын цалин хөлс		32 603,9	39 484,3	43 603,5	65 407,7	84 555,4	67 037,8	72 217,6	404 910,2
	Мэдээллийн сангийн шууд хөрөнгө оруулалтын зардал		10 200,0	140 264,2	30 000,0	12 342,4	138 350,0	355 408,0	339 963,9	1 026 528,5
	Сургалт, сурталчилгааны зардал	19 170,6	21 348,2	67 075,6	73 178,4	73 096,1	85 998,6	63 701,6	87 637,0	491 206,1
Орлогод эзлэх хувиар хувиарлагдах зардал (11.8%)	3 586,6	32 456,7	92 964,2	184 803,9	108 767,8	136 103,5	96 439,2	267 234,4	922 356,4	
ЖДСангаас олгосон нөхөн төлбөрийн үлдэгдэл									16 015,5	
ЖДСанд даатгагчдаас төвлөрсөн хөрөнгийн үлдэгдэл									267 974,5	

- Жолоочийн даатгалын тухай хуулийн 22.4-д Жолоочийн даатгалын сангийн хөрөнгө үндсэн зорилгоо хэрэгжүүлэхэд хүрэлцэхгүй болсон тохиолдолд АЖДХ-ны Удирдах зөвлөлийн шийдвэрээр Холбооны гишүүнээс хөрөнө татан төвлөрүүлж болно.


- Санхүүгийн зохицуулах хорооны баталсан журмын 2.4-д дээрхийн адил зөвшөөрсөн заалт бий

АЖДХолбоо нь Жолоочийн хариуцлагын даатгалын гэрээ болон нөхөн төлбөрийн даатгагч, даатгуулагч, хохирогчийн болон жолоочийн даатгалтай холбоотой үйл ажиллагааны мэдээллийг мэдээллийн нэгдсэн системд оруулах үүрэгтэй гэдгийг Жолоочийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасныг хэрэгжүүлж байгаа. Үүнийг улирал жилээр 18 төрлийн статистик тайлан болгон боловсруулж түүний хадгалалтын аюулгүй байдлыг хангаж ажилладаг юм. Энэ статистикийг холбогдох байгууллага ашиглаж байна.


үлдэгдэл

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаанд хэн ямар үүрэгтэй оролцдог тухай та бүхэнд танилцуулья.

ДААТГАЛЫН КОМПАНИАР ДААТГАЛЫН ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ДАРААЛАЛ



ЗУУЧЛАГЧААР ДААТГАЛЫН ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ДАРААЛАЛ



ДААТГУУЛАГЧ ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ ГАРГАЖ НӨХӨН ТӨЛБӨР АВАХ ДАРААЛАЛ

